



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/42/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2023 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 171

танай _____ -ны № _____ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.САРАНТУНГАЛАГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өмнөговь аймгийн биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бүдний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийтийн биеийн тамирын арга хэмжээнд зориулан албан хаагчдын хувцасны зардалд байгууллагаас хөрөнгө зарцуулсан, тээвэр шатахууны зардлын шатах тослох материалын орлого, зарлагын тайлан хийгээгүй, жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөөгүй, урсгал засварын зардлаас хөрөнгө, эд хогшил бэлтгэсэн, ажил гүйлгээг хэсэгчлэн шууд гэрээ байгуулсан, гэрээ дүгнээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, Иргэний тухай хуулийн 343 дугаар зүйлийн 343.1, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого болон мэргэжлийн спортын хөгжлийн асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд

016020253

хамааруулж, түүнтэй уялдуулан Биеийн тамир, спортын тухай хуульд биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын талаарх зохицуулалтыг тусгаснаар тус газар нь биеийн тамир, спортын бодлого барьсан төрийн захиргааны байгууллага болж бүтэц өөрчлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон усан бассейн, заалны түрээсийн төлбөрийн нэмэлт орлого 36.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант хугацаанд Монголын бүх ард түмний спортын XV, Үндэсний спортын VII дугаар наадамд спортын төрлүүдээр амжилттай оролцсон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>99,129,643.70</u> | <u>133,642,407.30</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - |
| 33 | АВЛАГА | - | - |
| 34 | УРЬДЧИЛГАА | 600,000.00 | 32,660,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 32,060,000.00 |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 600,000.00 | 600,000.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 600,000.00 | 600,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 98,529,643.70 | 100,982,407.30 |
| 351 | Түүхий эд материал | 65,323,270.10 | 78,266,633.70 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 64,717,065.10 | 77,890,228.70 |
| 35130 | Эм боох материал | 606,205.00 | 376,405.00 |
| 354 | Хангамжийн материал | 33,206,373.60 | 22,715,773.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,107,575.00 | 5,143,925.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,612,698.60 | 14,288,348.60 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,023,000.00 | 80,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 6,463,100.00 | 3,203,500.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>7,211,120,669.63</u> | <u>8,583,220,393.26</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7,211,120,669.63 | 8,583,220,393.26 |
| 392 | Биет хөрөнгө | 7,206,092,099.63 | 7,474,052,603.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 12,476,751,219.85 | 13,084,678,169.85 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (9,869,563,004.92) | (10,146,852,566.11) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 64,050,000.00 | 37,050,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (36,983,333.41) | (16,050,000.13) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 385,666,743.82 | 396,641,443.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (99,080,016.02) | (167,227,343.00) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 398,557,336.90 | 423,987,336.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (108,180,918.59) | (152,348,510.07) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 23,350,000.00 | 42,650,000.00 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 3,966,524,072.00 | 3,966,524,072.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 5,028,570.00 | 1,109,167,790.00 |
| 39301 | Програм хангамж | 5,498,900.00 | 5,498,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,725,130.00) | (2,505,910.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,254,800.00 | 1,106,174,800.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>7,310,250,313.33</u> | <u>8,716,862,800.56</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>7,310,250,313.33</u> | <u>8,716,862,800.56</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 7,310,250,313.33 | 8,716,862,800.56 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,648,731,326.10 | 5,753,651,326.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,648,731,326.10 | 5,753,651,326.10 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 422,640,344.26 | 724,332,831.49 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 422,640,344.26 | 422,640,344.26 |

| | | | |
|----------|--|--------------------------------|--------------------------------|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 301,692,487.23 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,238,878,642.97 | 2,238,878,642.97 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>7,310,250,313.33</u> | <u>8,716,862,800.56</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 840,660,771.42 | 1,623,697,270.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 191,721,671.42 | 627,226,950.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 181,399,046.72 | 627,226,950.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 10,322,624.70 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 648,939,100.00 | 996,470,320.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 359,011,700.00 | 404,903,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 359,011,700.00 | 404,903,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 48,871,000.00 | 159,019,920.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,497,000.00 | 122,229,920.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,374,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 36,790,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 241,056,400.00 | 432,546,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 241,056,400.00 | 432,546,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 962,773,403.30 | 1,322,004,782.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 962,773,403.30 | 1,322,004,782.77 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 850,859,748.51 | 1,128,923,342.38 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 257,290,298.83 | 297,509,351.57 |
| 210101 | Үндсэн цалин | 251,885,501.32 | 215,306,302.43 |
| 210102 | Нэмэгдэл | 5,404,797.51 | 22,710,258.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 44,147,522.86 |
| 210104 | Урамшуулал | - | 15,345,268.14 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,734,099.31 | 37,277,358.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,457,399.55 | 25,348,635.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,557,999.43 | 2,982,180.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,058,300.02 | 2,385,724.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 514,600.33 | 596,456.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,145,799.98 | 5,964,361.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 94,559,775.07 | 130,408,453.77 |

| | | | |
|-------------|---|--------------------------------|------------------------------|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,195,763.07 | 62,739,503.17 |
| 210302 | Түлш, халаалт | 65,842,574.00 | 40,697,254.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,521,438.00 | 26,971,696.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,490,398.00 | 39,824,265.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,872,200.00 | 2,312,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,167,500.00 | 4,333,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 661,000.00 | 1,464,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 817,120.00 | 1,766,940.90 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,972,578.00 | 1,942,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 28,003,674.50 |
| 2105 | Нормативт зардал | 14,187,800.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,187,800.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,432,000.00 | 29,042,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,432,000.00 | 29,042,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 921,000.00 | 2,841,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 921,000.00 | 2,841,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,916,332.00 | 5,045,256.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,916,332.00 | 1,430,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 700,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 380,756.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 2,084,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 416,328,045.30 | 586,974,657.37 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,545,100.00 | 188,620,731.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,902,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 360,782,945.30 | 396,451,926.37 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 111,913,654.79 | 193,081,440.39 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 47,067,344.00 | 16,893,821.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,766,885.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,300,459.00 | 16,893,821.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 64,846,310.79 | 176,187,619.39 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,846,310.79 | 176,187,619.39 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>(313,834,303.30)</u> | <u>301,692,487.23</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 5,412,666.42 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,412,666.42 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (5,412,666.42) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>(319,246,969.72)</u> | <u>301,692,487.23</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 648,939,100.00 | 996,470,320.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 648,939,100.00 | 996,470,320.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 359,011,700.00 | 404,903,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 359,011,700.00 | 404,903,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 48,871,000.00 | 159,019,920.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,497,000.00 | 122,229,920.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,374,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 36,790,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 241,056,400.00 | 432,546,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 241,056,400.00 | 432,546,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 648,939,100.00 | 960,065,620.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 648,939,100.00 | 960,065,620.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 537,025,445.21 | 766,984,179.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 257,290,298.83 | 297,509,351.57 |
| 210101 | Үндсэн цалин | 251,885,501.32 | 215,306,302.43 |
| 210102 | Нэмэгдэл | 5,404,797.51 | 22,710,258.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 44,147,522.86 |
| 210104 | Урамшуулал | - | 15,345,268.14 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,734,099.31 | 37,277,358.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,457,399.55 | 25,348,635.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,557,999.43 | 2,982,180.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,058,300.02 | 2,385,724.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 514,600.33 | 596,456.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,145,799.98 | 5,964,361.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 94,559,775.07 | 130,408,453.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,195,763.07 | 62,739,503.17 |
| 210302 | Түлш, халаалт | 65,842,574.00 | 40,697,254.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,521,438.00 | 26,971,696.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,358,300.00 | 9,594,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 345,000.00 | 1,372,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,167,500.00 | 2,860,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 595,000.00 | 1,464,300.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|------------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 510,300.00 | 572,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 740,500.00 | 3,325,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 86,413,540.00 | 71,130,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 204,200.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 86,209,340.00 | 71,130,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 921,000.00 | 2,841,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 921,000.00 | 2,841,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,909,832.00 | 5,045,256.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,909,832.00 | 1,430,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 700,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 380,756.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 2,084,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,838,600.00 | 213,177,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,838,600.00 | 211,275,260.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,902,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 111,913,654.79 | 193,081,440.39 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 47,067,344.00 | 16,893,821.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,766,885.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,300,459.00 | 16,893,821.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 6,593,998.17 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,593,998.17 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 64,846,310.79 | 143,342,386.22 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,846,310.79 | 143,342,386.22 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 26,251,235.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 26,251,235.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | - | 36,404,700.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 36,404,700.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 36,404,700.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 36,404,700.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 36,404,700.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (36,404,700.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |

| | | | |
|----|--|---|---|
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---------------------------------|-------------------------|-------------------------|--|
| 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,648,731,326.10 | 2,238,878,642.97 | 759,562,672.35 | 7,647,172,641.42 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,648,731,326.10 | 2,238,878,642.97 | 759,562,672.35 | 7,647,172,641.42 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 1,104,920,000.00 | - | - | 1,104,920,000.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 301,692,487.23 | 301,692,487.23 |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,753,651,326.10 | 2,238,878,642.97 | 1,061,255,159.58 | 9,053,785,128.65 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 870,908,000.00 | 687,514,015.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 870,908,000.00 | 687,514,015.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 869,443,000.00 | 686,049,019.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 435,649,100.00 | 297,509,351.57 |
| 210101 | Үндсэн цалин | 365,352,800.00 | 215,306,302.43 |
| 210102 | Нэмэгдэл | 35,777,900.00 | 22,710,258.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,900,000.00 | 44,147,522.86 |
| 210104 | Урамшуулал | 15,618,400.00 | 15,345,268.14 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,518,500.00 | 37,277,358.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,752,500.00 | 25,348,635.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,441,500.00 | 2,982,180.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,553,200.00 | 2,385,724.52 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 888,300.00 | 596,456.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,883,000.00 | 5,964,361.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 155,222,500.00 | 130,408,453.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 65,900,000.00 | 62,739,503.17 |
| 210302 | Түлш, халаалт | 64,774,000.00 | 40,697,254.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 24,548,500.00 | 26,971,696.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,594,100.00 | 9,594,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,372,800.00 | 1,372,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,860,000.00 | 2,860,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,464,300.00 | 1,464,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 572,000.00 | 572,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,325,000.00 | 3,325,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 107,535,600.00 | 107,535,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 107,535,600.00 | 107,535,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,860,000.00 | 2,841,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,860,000.00 | 2,841,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,435,000.00 | 5,045,256.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,430,000.00 | 1,430,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 850,000.00 | 850,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 450,000.00 | 300,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 85,500.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 35,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 380,756.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,084,500.00 | 2,084,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 98,628,200.00 | 95,837,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,726,200.00 | 93,935,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,902,000.00 | 1,902,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,465,000.00 | 1,464,996.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,465,000.00 | 1,464,996.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,465,000.00 | 1,464,996.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 870,908,000.00 | 687,514,015.61 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 404,903,900.00 | 398,309,901.83 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 404,903,900.00 | 398,309,901.83 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 466,004,100.00 | 289,204,113.78 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 466,004,100.00 | 289,204,113.78 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 159,019,920.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 159,019,920.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 117,339,860.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,339,860.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,339,860.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,428,825.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 15,428,825.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,428,825.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 26,251,235.00 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 26,251,235.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 159,019,920.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 159,019,920.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 122,229,920.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,790,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 297.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 297.7 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээний орлогын 2.6 сая төгрөгийг бусад орлогоор бүртгэж тайлагнасан
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 36.8 сая төгрөгийн нэмэлт орлогыг 1200041 үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих дансанд тайлагнасан
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улс, орон нутгийн данснаас төвлөрүүлсэн шилжүүлэг 149.9 сая төгрөгөөр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулж тайлагнаагүй
- Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 36.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй байна.
- Улсын төсвийн данснаас төвлөрүүлсэн 6.6 сая төгрөг, нэмэлт данснаас төвлөрүүлсэн 26.2 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг 213403 орон нутгийн төвлөрүүлэх шилжүүлэг дансанд бөөн дүнгээр тайлагнасан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Байгууллагын засвар үйлчилгээнд зарцуулсан 39.1 сая төгрөгийн барилгын засварын материалыг үлдэгдлээр тайлагнасан байна.

Аудитаар нийт 64.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 2.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 61.8 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, хууль тогтоомжтой холбоотой 1 зөвлөмж өгсөн.

Мөн завсрын аудитаар 48.4 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, нийцлийн аудитын асуудлаар 234.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

Төлбөрийн акт

Нийтийн биеийн тамирын арга хэмжээнд зориулан албан хаагчдын хувцасны зардалд 2.5 сая төгрөгийг байгууллагаас зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”-д заасантай нийцэхгүй байна.

Албан шаардлага

- Байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 4.3 сая төгрөгийн тээвэр шатахууны зардлын шатах тослох материалын орлого, зарлагын тайлан хийгээгүй, жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөөгүй, харилцахын гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангаж ажиллаагүй,
- Урсгал засварын зардлаас спорт заалны хүндэтгэлийн суудал, эргэлтийн насос, гал тогоо, хананы тек, текний сандал, 3 дамжлагат угаалтуур зэрэг 25.4 сая төгрөгийн хөрөнгө, эд хогшил бэлтгэж, ажил гүйлгээг хэсэгчлэн шууд гэрээ байгуулж ажилласан,
- Ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 12 сард байгуулан "Спорт заалны хүндэтгэлийн хана хийх угсрах ажил"-д 17.8 сая төгрөг, "Спорт заалны угтагчийн хэсэг хийх, угсрах ажил"-д 14.3 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан боловч уг ажлууд нь гэрээний хугацаандаа хийгдээгүй, хөрөнгөө хүлээж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Иргэний тухай хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 "Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Завсрын аудитаар өгсөн албан шаардлага:

1. Төлбөртэй үйлчилгээний орлогын анхан шатны бүртгэл, тайлан, хяналт, хангалтгүй байгаа нь бэлэн мөнгөний эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн,
2. Тайлант хугацааны төлбөртэй үйлчилгээний орлогыг тухай бүр Төрийн сан банканд тушааж ажиллаагүй,
3. Хүчний кабель нийлүүлэх, спорт цогцолборын гражид халаалтын систем хийх ажил, усан бассейны халаах бойлерын шугам янзлах, гадагш зөөвөрлөж гаргах, угсрах зэрэг ажлуудад худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгүүлэх гэрээг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулаагүй, хөрөнгө зарцуулах шийдвэр гаргаагүй, ажил гүйлгээг хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.3 "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана", 8.3 "Энэ журмын 2.6-д заасан үйл ажиллагаанд тухайн байгууллагын төсвийн эрх захирагч, нягтлан бодогч нар хяналт тавьж ажиллана"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, үйлчилгээнд борлуулалтын Е баримт олгоогүй, байгууллагын худалдан авалт бүрд төлбөрийн Е баримт шивүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", 29 дүгээр зүйлийн 29.1.1 "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөртэй үйлчилгээнд борлуулалтын Е баримт олгох, худалдан авалт, зарлагын гүйлгээ бүрд төлбөрийн Е баримтыг анхан шатны баримтаар бүрдүүлж ажил гүйлгээг хийж хэвших зөвлөмж хүргүүлэх

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | | 1 | | |

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|--|-----------------------------|----------------------|--------------|-----------|--------------|---------------|------------|-----------------|--------------|----------|----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 10 | 410.4 | 6 | 297.7 | 1 | 2.5 | 2 | 110.2 | 1 | 0 |
| | Дүн | 10 | 410.4 | 6 | 297.7 | 1 | 2.5 | 2 | 110.2 | 1 | 0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 1 | 234.9 | | | | | 1 | 234.9 | | |
| | Дүн | 1 | 234.9 | | | | | 1 | 234.9 | | |
| | НИЙТ ДҮН | 11 | 645.3 | 6 | 297.7 | 1 | 2.5 | 3 | 386.6 | 1 | 0 |